



АРВАЙХЭЭР-БАЯНХОНГОР ЧИГЛЭЛИЙН УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМААС  
УЯНГА СУМ ХҮРТЭЛХ 50 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТЭЗҮ, АЖЛЫН  
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР  
/ӨВӨРХАНГАЙ АЙМАГ, УЯНГА СУМ/

Дугаар АЗД-009

2024 оны 08 дүгээр сарын 30-ны өдөр

Арвайхээр хот


1	Боловсруулах үндэслэл, зорилго	<b>Боловсруулах үндэслэл:</b> Улсын төсвийн хөрөнгөөр. <ul style="list-style-type: none"><li>- Уянга сумын Засаг даргын 20....оны.....дугаар сарын.....-ний өдрийн дугаар .....захирамжаар /..... м2 талбай/</li></ul>
2	Төслийн захиалагч	- Өвөрхангай аймгийн ЗДТГазар.
3	Байршил	Арвайхээр-Баянхонгор чиглэлийн улсын чанартай авто замаас Уянга сум хүртэлх чиглэлд.
4	Зориулалт	- Арвайхээр-Баянхонгор чиглэлийн улсын чанартай авто замаас Уянга сум хүртэлх орчны дэд бүтээцийг шинэчлэн сайжруулах, ая тухтай зорчих орчин бий болгох.
5	Замын техникийн зэрэг	- Нутаг дэвсгэрийн зам, багийн төвийг төв замтай холбох, хатуу хучилттай авто зам
6	Замын хучилтын хийц	- Боловсронгуй төрлийн хучилттай, Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ.
7	Газрын бартаалаг, төвөгшил	- Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
8	Зураг төсөл боловсруулах үе шат, хугацаа	- 1-ье шаттай ажлын зураг:
9	Зураг төсөл боловсруулах байгууллага	- Гэрээгээр
10	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
11	Баримт бичгийн бүрдэл	<b>Бүтээц 1. БИЧИГЛЭЛИЙН МАТЕРИАЛ:</b> <ul style="list-style-type: none"><li>- Зураг төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбилцолын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх, батлагдсан ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, нэгдсэн төсөв болон бусад холбогдох бичиг баримтыг /иж бүрэн зураг төсөл/ CD-ээр захиалагчид хүлээлгэн өгөх,</li></ul> <p>Ажлын зураг төсвийг тус бүр /Эх хувь- 2%, Хуулбар-1% өнгөтөөр/, /3Ds, dwg, skp, pdf, jpg/ өргөтгөлөөр/;</p> <p><b>2. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГЛАЛ:</b></p> <p>Зам талбайн ажлын зураг:</p> <ul style="list-style-type: none"><li>- Байршлын схем ЕТ М1:1000- М1:5000;</li></ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Дэвсгэр зураг; М1:500;</li> <li>- Трассын тойм зураг М1:500;</li> <li>- Авто замын хөндлөн огтлол М1:100;</li> <li>- Авто замын дагуу огтлол М1:1000;</li> <li>- Ногоон байгууламжын ажлын зураг М1:500; М1:100; М1:50;</li> <li>- Дугуйн замын ажлын зураг М1:500; М1:100; М1:50;</li> <li>- Авто замын борооны ус зайлуулах, үерийн далан шуудуу, М1:500</li> <li>- Үерийн усны хоолойн ажлын зураг М1:100</li> </ul> <p>Инженер шугам сүлжээ ажлын зураг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гэрэлтуулэгийн ажлын зураг М1:100</li> </ul>
12	<p>Автозам, ногоон байгууламжийн онцгой нөхцөл</p> <p>1. Амрах талбай, тохижилт</p> <p>Авто замын ажлын зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам, гүүр зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, "Авто зам төсөллөх" ЗЗБД22-004-2016, "Авто зам төсөллөх" БНБД 32.01.07, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНБД 32-02-12, Монгол улсын стандарт Автозамын салбарт мөрдөх стандартын замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хашилт чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2007, MNS 4597:2014, MNS 4159:2014, MNS 4980:2014, "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөтийн нормаль" Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замын төлөвлөх заавар MNS 6056:2009, "Зам замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох заавар" ЗЗБНБД81-013—2016, "Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм" ЗЗБНБД83-017-2016, Засгийн газрын 2016 оны 07-р сарын 0-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрэм", Авто зогсоол дүрэм, норм, Авто зогсоол БНБД21-05-10, MNS5342:2007 авто зогсоол, ангилал ба ерөнхий шаардлага болон бусад холбогдох норм дүрм стандартуудыг үндэслэх,</p> <ul style="list-style-type: none"> <li>- "Геодези зураг зүйн тухай" хуулийн 6.1.3 дугаар заалт, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах,</li> <li>- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх, зам барилгын ажлын үед геометр хэмжээг хангах, хэмжилтийн төсөл-даалгавар боловсруулах.</li> <li>- Автозамын зорчих хэсгийн төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах, захиалагчийн саналыг тусгах.</li> <li>- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах ба зураг төслийг боловсруулахдаа холбогдох байгууллагуудтай зөвшилцсэн байх. Хэвтээ тэмдэглэгээний ажлын зургийг өмнөх ашиглаж байсан үндсэн замын тэмдэглэгээтэй уялдуулах, мөн эгнээ байр шилжсэн тухай мэдээллийн /өндрийн/ тэмдэгийн байршлыг зааж төлөвлөх,</li> <li>- Авто зам, уулзвар болон авто зогсоол, амрах талбайн ус зайлуулах байгууламжийг цогц байдлаар шийдвэрлэх, замын дагуух гадаргуун ус зайлуулах байгууламжийг орчноор нь тооцож шийдвэрлэх,</li> </ul> <p>2. Ногоон байгууламж:</p>

		<ul style="list-style-type: none"> <li>- Багийн төвийн хэсэгт тариалах мод, бут, сөөг, нь тухайн орон нутагт дасан зохицсон, нутагшсан, төрөл зүйлийн биологийн онцлогт тохирсон үр суулгац байна. Үр суулгацыг тариалахад шаардлагдах тухайн орон нутгийн хөрсний шинж чанар бүтцээс хамаарч хар шороо, элс, бууц, эрдэс бордоог агро техникийн шаардлагын дагуу төлөвлөх,</li> </ul> <p><b>3.Бусад:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Түүх соёлын үнэт өв дурсгал замын трасст орсон тохиолдолд холбогдох байгууллагуудтай зөвшилцөн хамгаалах болон нүүлгэн шилжүүлэх ажлыг эцэслэн шийдвэрлэсэн байна.</li> <li>- Ажлын зурагт бусад инженерийн бэлтгэл арга хэмжээ, шугам сүлжээний одоогийн байдал болон төлөвлөлтийг нэг дэвсгэр зураг дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтполын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай.</li> <li>- Барилгын болон авто замын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тушаал шийдвэрийн дагуух хийсэн ажлын төсвийг боловсруулна. /Төсвийн программаар/</li> </ul>
13	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<p><b>Инженерийн бэлтгэл арга хэмжээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Үерийн хамгаалалтын сувагт нийлэх гуу жалга, түүний ус хүлээн авах барилга байгууламжийг төлөвлөх,</li> </ul> <p><b>Цахилгаан хангамж, гэрэлтуулэг:</b></p> <p>Ажлын зураг төслийг боловсруулахдаа “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ны гаргасан техникийн нөхцлийн дагуу төлөвлөж буй автозамын трассад орсон цахилгаан дамжуулах агаарын шугам, тулгуур, кабель шугам сүлжээ болон трансформаторын дэд өртөө, хүчний самбаруудыг ашиглахаар төлөвлөх,</p> <p>Мөн автозам, уулзварт төлөвлөгдөх гэрэлтүүлэг нь уулзвар, замын зорчих хэсэг болон явган хүний зам талбайг бүхэлд нь гэрэлтүүлж байхаар сүүлийн үеийн технологи болох эрчим хүчний хэмнэлттэй, байгалийн өнгөөр гэрэлтэх USD гэрэлтүүлэг сонгох, эсвэл түүнтэй дүйцэхүйц техникийн үзүүлэлттэй гэрэлтүүлэгч байх, гэрэлтүүлэгч шон нь үйлдвэрийн хийцтэй, гэрэлтүүлгийн самбар нь хугацааны фото релетэй ажлын зурагтай байхаар зураг төсөлд оруулах.</p> <p>Монгол улсын их хурлын 52 дугаар тогтоол, БОАЖЯ-ны сайдаас ирүүлсэн 2023 оны №01/713 тоот албан бичгийн хүрээнд БХБЯ-ны 2023 оны 03 сарын 03 өдрийн №2/738 дугаар чиглэлийн дагуу Авто замын хажуугийн зогсоол тутамд цахилгаан авто машин цэнэглэх 1 түргэн цэнэглэгчтэй байхаар ажлын зурагт төлөвлөх.</p> <p>Хүчний кабель шугам, хуваарилах байгууламж, трансформаторын дэд өртөөг “Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-ний боловсруулан баталсан техникийн шаардлагын тодорхойлолтуудад үндэслэх, мөн цахилгаан хангамжийн болон гэрэлтүүлгийн ажлын зураг төсөлд орон нутгийн мэргэжлийн ашиглагч байгууллагуудын саналыг тусгах.</p>
14	Барилгын гүйцэтгэгч байгууллага	Гэрээгээр
15	Зөвшилцөх байгууллага	Зам, тээврийн хөгжлийн яам, аймгийн ГХБХБГазар, Уянга, Тарагт сумын ЗДТГ, Бусад инженерийн шугам сүлжээ хариуцсан холбогдох байгууллагууд,
16	Эдийн засгийн тооцоо төсөөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.

ЗӨВШӨӨРСӨН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

  
Б.МОНХБАТ

ХЯНАСАН:

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА


  
Т.АРИУНБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

  
Г.ТҮВШИНТӨР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН АВТОЗАМЫН  
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

  
Б.ЦОГТБААТАР

